

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2019 оны 11 дүгээр сар/**

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар болон химийн аргаар тодорхойлж байна.


2019 оны хүйтний улирлын 11 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 47мкг/м³-ээр буюу 43%-иар, PM10 тоосонцор 87мкг/м³-ээр буюу 42%-иар тус тус бага, хүхэрлэг хий 28мкг/м³-ээр буюу 85%-иар их, азотын давхар исэл 13мкг/м³-ээр буюу 29%-иар их байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2018 оны 11 дүгээр сар	2019 оны 11 дүгээр сар
PM2.5 тоосонцор	50	108	61↓
PM10 тоосонцор	100	208	121↓
Хүхэрлэг хий, SO ₂	50	33	61↑
Азотын давхар исэл, NO ₂	50	45	58↑

* ↓ бага; ↑ их; ↔ ойролцоо түвшинд /±5%.

Улаанбаатар хотын сүүлийн 5 жилийн хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт харуулав.


PM2.5 тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM2.5 тоосонцорын сарын дундаж агууламж, 2015-2019 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2019 оны 11 дүгээр сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43%-иар бага, Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-аас 1.2 дахин их байна (Зураг 1).


PM10 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2015-2019 он

Агаар дахь PM10 тоосонцрын 2019 оны 11 дүгээр сарын дундаж агууламжийг 2018 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад 42%-иар бага, АЧС дахь ХА-тай харьцуулахад 1.2 дахин их байна (Зураг 2).


Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 3. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2015-2019 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2019 оны 11 дүгээр сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин, АЧС дахь ХА-аас 1.2 дахин тус тус их байна (Зураг 3).

Азотын давхар исэл (NO₂)



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2015-2019 он

Азотын давхар ислийн 2019 оны 11 дүгээр сарын дундаж агууламжийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 29%-ээр их, АЧС дахь 1.2 дахин их байна (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС